**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ**

Өөрийн байр, 3 дугаар хороо,
Налайх дүүрэг, Улаанбаатар хот, 12610 0017
Утас: (976) 7575 1001
Цахим шуудан: park@nad.ub.gov.mn
Цахим хуудас: www.nalaikhpark.mn

2023.06.16 № 81

танай 2023.01.06 -ны № 03/132 -т

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭСТ

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2022 оны ажлыг дүгнэх ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжийн дагуу хийж хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Парк Газар
Дарга
Сосор Батжаргал
2023.06.16 11:32

## НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДЫН 2022 ОНЫ АЖЛЫГ ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСГЭЭС ИРҮҮЛСЭН ЗӨВЛӨМЖИЙН ДАГУУ ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН БИЕЛЭЛТ

2023 оны 6 сарын 16 Налайх дүүрэг

| № | Зөвлөмж | Зөвлөмжийн биелэлт |
|---|---|---|
| 1 | Нийтийн мэдээллийн ил тод байлын тухай хуульд заасан Нээлттэй мэдээллүүдийг байгууллагын цахим хуудаст байршуулах | Байгууллагын цахим хуудсанд Үйл ажиллагааны ил тод байдал, Төсөв санхүүгийн ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал, Худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн 4 төрлөөр нээлттэй байдлыг хангаж ажилладаг бөгөөд хамтран ажиллах хүсэлтэй иргэд, ААН-үүдэд зориулж төсөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, тэргүүлэх чиглэл болон үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль тогтоомжийн өөрчлөлт зэргийг цаг тухай бүрт нь шинэчлэн мэдээллэдэг. |
| 2 | Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа тухайн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний агуулгыг оновчтой тодорхойлж, шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэхэд анхаарах | Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа тухайн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний агуулгыг оновчтой тодорхойлж, шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь хэрэгжих боломжтой, тоон ба чанарын утгаар илэрхийлэгдэд анхааран ажиллаж батлуулсан. |
| 3 | "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд туссан хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа үг үсэг, утга найруулгад анхаарч албан бус товчилсон үг хэрэглэхгүй, тоон мэдээ мэдээллийн үнэн бодитой эсэхэд анхаарах | Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах стандартын сургалтыг дотооддоо зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулсан.<br>Тоон мэдээ мэдээллийн үнэн бодитой эсэхэд анхааран нягтлан шалгаж, тайлан мэдээг хүргүүлж байна. |
| 4 | "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлгээ хийх | Үнэлгээг тус журмын дагуу гүйцэтгэж байна. |
| 5 | "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний гүйцэтгэл нь хүрэх түвшинд хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан, нөхцөлийг тодорхой тусган үнэлгээний дүнг байгууллагын зөвлөлийн даргын6хурлаар хэлэлцүүлэх, хурлаас гарсан дүгнэлт зөвлөмжийг холбогдох хэлтэс, албан хаагчдад хүргүүлж, үр дүнг тооцон ажиллах | Байгууллагын даргын зөвлөлийн хурлаар "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний үр дүнг хэлэлцэн, удаашралтай байгаа ажлуудын шалтгаан нөхцлийг тодруулж, цаашид хэрхэн эрчимжүүлэх талаар асуудал дэвшүүлэн ажиллаж байна. |

| | | |
|---|---|---|
| 6 | Албан хэрэг хөтлөлтийн эдок систем ашиглалтыг сайжруулах, явуулсан албан бичгийн бүртгэлд хариутай эсэх тэмдэглэлийг тогтмол хийх | Эдок системд 2023 оны эхний хагас жилийн байдлаар албан хаагчдаас гаргасан зөрчил байхгүй бөгөөд албан бичгийн шийдвэрлэлтийн дундаж хоног 2,63 байна.<br>Явуулсан бичгийн хариутай эсэх тэмдэглэлийг тогтмол хийж байна<br>ННЗБ-ын Эдок системийг албан бичиг солилцооны дундын систем (DOCX)-тэй холбогдож бусад төрийн байгууллагуудтай цахимаар албан бичиг илгээх, хүлээн авах болсонтой холбогдуулан гэрээ байгуулах хүсэлтийг хүргүүлсэн. |
| 7 | Захирамжлалын баримт бичигт зайлшгүй үндэслэл болгох хуулийн заалтыг тусгах | Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дах хэсгийг байгууллагын даргаас гаргаж буй тушаалын үндэслэл хэсэгт тогтмол оруулж байна. |
| 8 | Захирамжлал, зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийг боловсруулах, батлуулах, зохион бүрдүүлэхдээ MNS 5140-1-2021, MNS 5140-2-2021, MNS 5140-3-2021 стандартыг тогтмол мөрдөн ажиллах | Байгууллагын албан хаагчдад зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийг боловсруулах, батлуулах, зохион бүрдүүлэхэд шаардлагатай стандартын сургалтыг орж 9 албан хаагч хамрагдсан. |
| 9 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дугаар захирамжаар батлагдсан "Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай журам"-ыг байгууллагын нийт албан хаагчдад танилцуулж, өргөдөл гомдлыг шийдвэрлэх явцад гаргасан зөрчлийг арилгах, хуулийн хугацаа хэтрүүлэхгүй байх | Иргэнээс ирүүлсэн 1, албан хаагчдаас ирүүлсэн 6 өргөдлийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэн хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг улирал тутам НЗДТГ-ын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд тайлагнаж байна. Шийдвэрлэлтийн дундаж хоног 1 |

ХЯНАСАН
ДАРГА С.БАТЖАРГАЛ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЖИЛТАН Д.НОМИН-ЭРДЭНЭ